Стандартчилал итгэмжлэгдсэн лаборатори TL № 08

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй

LAND OWNER

"GREEN LAB" LLC

ХӨРС СУДЛАЛЫН ЛАБОРАТОРИ

GREEN LAB

Монгол улс, Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг
6-р хороо, Нет Капитал байр 10 давхар 02 тоот
Утас/Факс: 72702020, 88950626
E-mail: landownermongolia@gmail.com

**Дээж ирсэн огноо:** 2022.06.02-07

**Шинжилгээ хийлгэж буй байгууллага, хувь хүн:** " Төгрөг баян хангай" LLC № 22/2493

**Холбоо барих дугаар:** 70168088, 88103741

**Дээж авсан газар:** Улаанбаатар хот НД-ийн Горхи-Тэрэлж БЦГ-т "RWT"

## Усны хүнд металл

| № | Лаб дугаар | Дээжний нэр | Агууламж мг/л | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Ni /Никель/ | Cd /Кадми/ | Pb /Хар тугалга/ | Zn /Цайр/ | Cr /Хром/ | Cu / Зэс/ |
| 1 | 22/2834 | Дээж-1 | 0.008 | <0.01 | 0.012 | 0.3 | 0.011 | 0.19 |
| **Зөвшөөрөгдөх дээд хэмжээ /MNS 4586:1998/** | | | **0,02** | **0,005** | **0,01** | **0,01** | **0,05** | **0,01** |

**Жич: Шинжилгээний хариу нь зөвхөн тухайн цэгийн дээжинд хамаарах ба хувилан олшруулахыг хориглоно.**

**Задаргаа хийсэн арга:** Атом шингээлтийн спектрометр

ШИНЖИЛГЭЭ ГҮЙЦЭТГЭСЭН: Шинжээч: Т. Гэрэлтуяа
Шинжээч: С. Мягмардаш
Шинжээч: М.Энхзаяа

ХЯНАСАН: Лабораторийн эрхлэгч Г.Ганчимэг /MS.c/

ХӨРС СУДЛАЛЫН ЛАБОРАТОРИ ЛАНД ОВНЕР ХХК Green lab 5703826 УБТТ 1255 УЛААНБААТАР ХОТ

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

**ГОРХИ-ТЭРЭЛЖИЙН БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗРЫН ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГАА**

12607 Улаанбаатар хот, Налайх дүүрэг,
1 дүгээр хороо, Туулын гүүр, Утас: 9818 3086,
И-мэйл: gorkhiterelj@mpa.gov.mn,
Вэбсайт: www.gorkhiterelj.mpa.gov.mn

2022.09.29 № 22/695

танай 2022.09.22-ны № 22/18 -т

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ, АУДИТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА Г.ЭНХМӨНХ ТАНАА

"Дүнхэн уулын буурал улиастай" ХХК нь Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2014 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 2014/132 дугаартай газар ашиглах гэрчилгээ авч, Горхи-Тэрэлжийн Байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүс болох Буурал улиастайд 1,9 га газарт газар ашиглах зөвшөөрөл авсан.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн тушаалаар талбайн хэмжээ 48707 м2 болгон нэмэгдүүлсэн болно.

Уг төсөлд байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ хийлгүүлэхээр уламжилж байна.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ М.ЭРДЭНЭБУЛГАН


5/25/2018 12:19:13 pm
12 pm
3 pm
N
Үерийн шуудуй
Ногоон байгууламж ба нөхөн сэргээлт
Трансформатор
Худаг
Хөрсний дээжлэлт
Хог хаягдлын цэг
Зогсоол
Засмал
Зогсоол
© 2018 Google
Image © 2018 CNES / Airbus
Google Earth

УБ-2

Монгол У[illegible]н Засгийн газрын
2004 оны [illegible]угаар тогтоолоор батлав.

# МОНГОЛ УЛС
# УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

0000088625

2014.09.23
/ Бүртгэсэн он,сар,өдөр /

9011508018
/ Улсын бүртгэлийн дугаар /

5884276
/ Регистрийн дугаар /

Дунхэн уулын буурал уливстай Хязгаарлагдмал хариуцлагатай компани
/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм
/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Шийдвэр 01 2014.09.22
/ шийдвэрийн нэр / / дугаар / / он, сар, өдөр /

4610 Гадаад худалдаа
/ код / / Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

7911 Аялал жуулчлал
8542 Гадаад хэлний түр сургалт явуулах
4330 Барилгын засвар үйлчилгээ
0130 Цэцэрлэгжүүлэлт

/ код / / Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй 1 000.00
/ хугацаа / / гишүүдийн тоо / / өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Улаанбаатар, Баянгол, 4-р хороо, 2 хороолол, энх тайвны өргөн чөлөө 5а, 26 тоот, Утас1: 88081562, Утас2: , Факс:
/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /

Улсын бүртгэлийн ерөнхий газрын бүртгэлийн газар
/ бүртгэсэн байгууллагын нэр /

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН ЯАМ

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын
2013.. оны .А-77 тоот тушаалын хавсралт

## МОНГОЛ УЛСЫН БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН ЯАМ УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ НУТАГ ДЭВСГЭРТ ГАЗАР АШИГЛАХ

# ГЭРЧИЛГЭЭ

Дугаар 2014/132

"Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай" Монгол улсын хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх заалтыг үндэслэн Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газраас ........Улаанбаатар........ аймаг /хот/ ........Налайх........ сум /дүүрэг/-ын нутагт орших ........Горхи тэрэлжийн БЦГ........ тусгай хамгаалалттай газар нутгийн ........Буурал улиастай........ нэртэй ........1.9........ га талбайг ........Аялал жуулчлал........ зорилгоор ашиглахыг "Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай" хуулинд заасан нөхцөл, журмын дагуу зөвшөөрч, энэхүү гэрчилгээг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ........9011508018/5884276/........ тоот гэрчилгээ /регистр/-тэй ........"Дүнхэн уулын буурал ХХК улиастай"........ -д ........Таван........ жилийн хугацаагаар олгов.

Энэхүү гэрчилгээ нь газар ашиглалтанд оруулсан аливаа өөрчлөлт, сунгалтыг тэмдэглэх хавсралттай бөгөөд хавсралтгүй бол хүчин төгөлдөрт тооцогдохгүй.

БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ
ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ НУТГИЙН УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГА ........................................ Т. ЭРДЭНЭЧИМЭГ

2014... оны 12... сарын ..09 өдөр

**Нэг. Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах ______ тоот гэрчилгээнд өөрчлөлт, сунгалт хийсэн бүртгэл**

| № | Зориулалт, өөрчлөлт, сунгалт | Бүртгэх, сунгах тухай шийдвэр | |
|---|---|---|---|
| | | Он, сар, өдөр | Өөрчлөлт хийж, тэмдэглэл хөтөлсөн нэгжийн даргын гарын үсэг, тэмдэг |
| **1.** | **Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны 08 дугаар сарын 30-ний өдрийн А/333 дугаар тушаал, Горхи-Тэрэлжийн БЦГ-ын хамгаалалтын захиргааны 2022.04.13-ны өдрийн №22/146, тоот саналыг тус тус үндэслэн талбайн хэмжээг 48707 м$^2$ болгон нэмэгдүүлэн нэгж талбарын эргэлтийн цэгийг өөрчлөв.** | **2022.09.02** | **ТХБНУГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч** (гарын үсэг) **Д.БАТМӨНХ** |

Тайлбар: Гэрчилгээнд өөрчлөлт, сунгалт хийхдээ Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалыг үндэслэн Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газрын дарга гарын үсэг зурж, яамны тэмдгээр баталгаажуулна.

**УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГТ ГАЗАР АШИГЛАХ 2014/132 ТООТ ГЭРЧИЛГЭЭНИЙ НЭМЭЛТ ХАВСРАЛТ**

/Гэрчилгээгүй бол хүчингүй/

***Нэг. Гэрчилгээгээр олгогдсон талбайн хэмжээ, үйл ажиллагааны чиглэл, өөрчлөлт***

| | *Гэрчилгээнд орох өөрчлөлтийн үндэслэл* | *Үйл ажиллагааны зорилго* | *Өргөдлийн бүртгэлийн дугаар* | *Хасагдах ба нэмэгдэх талбайн хэмжээ /га-гаар/* | *Үлдсэн талбайн хэмжээ /га-гаар/* |
|---|---|---|---|---|---|
| 1 | Анх олгосон: | *Аялал жуулчлал* | - | - | *1.9* |

## УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГТ ГАЗАР АШИГЛАХ 2014/132 ТООТ ГЭРЧИЛГЭЭНИЙ ХАВСРАЛТ

/Гэрчилгээгүй бол хүчингүй/

### *Хоёр. Гэрчилгээгээр олгогдсон талбайн булангийн цэгүүдийн солбицлын өөрчлөлтүүд*

| № | *Солбицол, өөрчлөгдөх үндэслэл* | *Өөрчлөгдсөн солбицлууд* |
|---|---|---|
| 1. | | |

**Солбицол, өөрчлөгдөх үндэслэл**

*Талбайн анхны солбицлууд:*

| | | |
|---|---|---|
| 1 | 107° 24' 22.217" E | 47° 54' 39.154" N |
| 2 | 107° 24' 25.257" E | 47° 54' 37.426" N |
| 3 | 107° 24' 19.647" E | 47° 54' 31.815" N |
| 4 | 107° 24' 16.244" E | 47° 54' 33.679" N |

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 11 сарын 26 -ний өдрийн А-417 тоот тушаалыг үндэслэн гэрчилгээг олгов.

ТХНУГ-ын дарга Т.Эрдэнэчимэг

2014.12.09

**Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/414 дугаар тушаал, Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 21/376 тоот саналыг тус тус үндэслэн газар ашиглах эрхийг 2024 оны 11 дүгээр сарын 26-ний өдрийг хүртэл сунгав.**

**2022 оны 01 дүгээр сарын 11 өдөр**

**ТХБНУГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.БАТМӨНХ**

1119278525 ±9085084

**Өөрчлөгдсөн солбицлууд**

Талбайн өөрчлөгдсөн солбицлууд:

| | | |
|---|---|---|
| 1 | 107° 24' 12.599" E | 47° 54' 36.382" N |
| 2 | 107° 24' 15.074" E | 47° 54' 39.072" N |
| 3 | 107° 24' 17.456" E | 47° 54' 39.308" N |
| 4 | 107° 24' 18.440" E | 47° 54' 38.633" N |
| 5 | 107° 24' 22.316" E | 47° 54' 39.813" N |
| 6 | 107° 24' 28.106" E | 47° 54' 36.399" N |
| 7 | 107° 24' 23.565" E | 47° 54' 32.046" N |
| 8 | 107° 24' 23.355" E | 47° 54' 32.116" N |
| 9 | 107° 24' 21.223" E | 47° 54' 33.029" N |
| 10 | 107° 24' 19.708" E | 47° 54' 31.672" N |
| 11 | 107° 24' 15.357" E | 47° 54' 34.079" N |
| 12 | 107° 24' 15.728" E | 47° 54' 34.484" N |

48707.00 квадрат метр

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн А/333 дугаар тушаал, Хамгаалалтын захиргааны 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн № 22/146 тоот саналыг тус тус үндэслэн эргэлтийн цэгт өөрчлөлт оруулав.

2022 оны 09 сарын 02-ны өдөр
Ой, ус, тусгай хамгаалалттай газрын кадастрын хэлтсийн дарга: Н.БАТЗАЯА

2022 оны 09 сарын 02-ны өдөр
Ой, ус, тусгай хамгаалалттай газрын кадастрын хэлтсийн мэргэжилтэн: Э.ЭРДЭНЭХҮҮ

# МОНГОЛ УЛСЫН
# БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
# САЙДЫН ТУШААЛ

2022 оны 08 сарын 30 өдөр Дугаар А/333 Улаанбаатар хот

Нэгж талбарын солбицол өөрчлөх, талбайн хэмжээ нэмэгдүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 34 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 36 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь хэсэг, 35 дугаар зүйлийн 35.3.4 дэх заалт, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1 дэх хэсэг, 39.1.11 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Налайх дүүрэг, Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүсэд Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамны (Хуучин нэрээр) 2014 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 2014/132 тоот газар ашиглах гэрчилгээтэй "Дүнхэн уулын буурал улиастай" ХХК-д олгосон 19000 м$^2$ талбайн хэмжээг Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 22/146 тоот саналын дагуу 48707 м$^2$ болгон нэмэгдүүлэн нэгж талбарын эргэлтийн цэгийг өөрчилсүгэй.

2."Дүнхэн уулын буурал улиастай" ХХК-ийн "Улсын тусгай хамгаалалттай нутаг дэвсгэрт газар ашиглах гэрчилгээ"-нд солбицол өөрчилсөн тэмдэглэл хийж, кадастрын мэдээллийн санд бүртгэхийг Ой, ус, тусгай хамгаалалттай газрын кадастрын хэлтэс (Н.Батзаяа)-т, "Улсын тусгай хамгаалалттай газрын нутаг дэвсгэрт газар ашиглах гэрээ"-г шинэчлэн байгуулан, газар ашиглалтын байдалд нь хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж, "Нүхэн жорлон, угаадасны нүх, техникийн шаардлага", "Тусгай хамгаалалттай газар нутаг дахь эко аялал жуулчлалын зориулалттай байр сууц, үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага" зэрэг стандартыг мөрдүүлэн ажиллахыг Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа (М.Эрдэнэбулган)-нд тус тус үүрэг болгосугай.

3."Газрын төлбөрийн тухай хууль"-д заасны дагуу ногдуулсан төлбөрийг хугацаанд нь төсөвт төлөх, "Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль"-д заасны дагуу нэмэгдүүлсэн талбайн хэмжээгээр тэмдэгтийн хураамж төлөх, "Газрын тухай хууль"-д заасны дагуу газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг тогтоосон журмын дагуу хийлгэх, гэрээгээр ашиглах газрыг хууль тогтоомжийн хүрээнд байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр, зориулалтын дагуу ашиглах, талбайн хэмжээг дур мэдэн өөрчлөхгүй байх, хэрэв байгаль орчинд сөрөг нөлөөтэй үйл ажиллагаа явуулан хууль тогтоомж, стандартыг зөрчсөн тохиолдолд газар ашиглах эрхийг дуусгавар болгох, буруутай үйл ажиллагаанаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэхийг "Дүнхэн уулын буурал улиастай" ХХК-д анхааруулсугай.

САЙД Б.БАТ-ЭРДЭНЭ

15??1083

МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

Засгийн газрын II байр, Нэгдсэн Үндэстний гудамж 5/2,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 19 66, Факс: (976-51) 26 61 71,
Цахим шуудан: contact@met.gov.mn,
Цахим хуудас: www.met.gov.mn

2022.10.21 № 13/6172

танай ____________-ны №____________-т

"ДҮНХЭН УУЛЫН БУУРАЛ УЛИАСТАЙ" ХХК-Д

Ерөнхий үнэлгээний дүгнэлт хүргүүлэх тухай

Танай байгууллагаас ирүүлсэн Улаанбаатар хотын Налайх дүүргийн Горхи-Тэрэлжийн БЦГ-т хэрэгжиж буй "Аялал жуулчлалын цогцолбор"-ын төсөлд "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай" хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, Засгийн газрын 2013 оны "Журам батлах тухай" 374 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан аргачлалын дагуу байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлээ.

Ерөнхий үнэлгээний дүгнэлтээр уг төсөлд батлагдсан аргачлалын дагуу байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай гэж үзэв.

Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудаст заасан нарийвчилсан үнэлгээний явцад тодруулах асуудлууд, онцгойлон анхаарах чиглэлийг харгалзан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгэж 2023 оны 1 дүгээр улиралд багтаан тус яаманд ирүүлэхийг үүгээр мэдэгдье.

Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудсыг хавсаргав.

Хавсралт... хуудастай

ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ Г.ЭНХМӨНХ

152279106

## ҮНЭЛГЭЭНИЙ ХҮСЭЛТ, БАРИМТ БИЧИГ ХҮЛЭЭН АВАХ МАЯГТ

***Төсөл хэрэгжүүлэгчийн нэр, хаяг:*** “Дүнхэн уулын буурал улиастай” ХХК, УБ-хот, Баянгол дүүрэг, 4-р хороо, 2-р хороолол, 5а-2б тоот
***Холбоо барих утас, И-мэйл хаяг:*** 976- 88081562
***Төслийн нэр:*** Аялал жуулчлалын цогцолбор
***Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, байршил: :*** УБ хот, Налайх дүүрэг, 6-р хороо, Горхи-Тэрэлжийн БЦГ-т хэрэгжинэ.

| Баримт бичгийн нэр | Шаардлагатай эсэх | Шаардлага хангасан эсэх | Тайлбар |
|---|---|---|---|
| Төсөл хэрэгжүүлэгчийн ерөнхий үнэлгээ хийлгэх тухай хүсэлт /албан бичиг/ | Тийм | + | |
| Эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан ТЭЗҮ, зураг төсөл | Тийм | | Эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан ТЭЗҮ, зураг төсөл хийлгэх. |
| Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө, хөтөлбөрт тусгагдсан эсэх /газрын зөвшөөрөл, ТХГН-т байрлах бол Хамгаалалтын захиргааны санал/ | Тийм | + | Горхи-Тэрэлжийн Байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны даргын 2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 22/695 дугаар албан бичиг. |
| Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлын тодорхойлолт | Үгүй | | |
| Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлан | Тийм | + | Байгаль орчны үнэлгээний “Баян хангай төгрөг” ХХК боловсруулсан. |
| Төсөл хэрэгжих орчны тойм зураг (топо, сансрын) | Тийм | + | |
| Тухайн сум, дүүргийн Засаг даргын тодорхойлолт | Үгүй | | |
| Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар /нотариатаар батлуулсан байх/ | Тийм | + | |

**Тусгай тэмдэглэл:**
**“Дүнхэн уулын буурал улиастай” ХХК-ийн төслийн “Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан”-г Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын “Аргачлал батлах тухай” 2014 оны А-117 дугаар тушаалын хавсралтын дагуу хийлгэх шаардлагатай гэж үзлээ.**

**Ерөнхий үнэлгээ хийлгэх хүсэлт, материалыг хянасан:**

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ЯАМНЫ ШИНЖЭЭЧ — О.АНУДАРЬ

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ**

# ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУУДАС

**2022 оны 10-р сарын 18** **Улаанбаатар хот**

**Төслийн дугаар** **Дугаар 2022/ОАн-46**

***Төсөл хэрэгжүүлэгчийн нэр, хаяг:*** "Дүнхэн уулын буурал улиастай" ХХК, УБ-хот, Баянгол дүүрэг, 4-р хороо, 2-р хороолол, 5а-2б тоот
***Холбоо барих утас, И-мэйл хаяг:*** 976- 88081562
***Төслийн нэр:*** Аялал жуулчлалын цогцолбор
***Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, байршил: :*** УБ хот, Налайх дүүрэг, 6-р хороо, Горхи-Тэрэлжийн БЦГ-т хэрэгжинэ.
**Газрын солбилцол:**

| № | X | Y |
|---|---|---|
| 1. | 107 24 12.599 | 47 54 36.382 |
| 2. | 107 24 15.074 | 47 54 39.072 |
| 3. | 107 24 17.456 | 47 54 39.308 |
| 4. | 107 24 18.440 | 47 54 38.633 |
| 5. | 107 24 22.316 | 47 54 39.813 |
| 6. | 107 24 28.106 | 47 54 36.399 |
| 7. | 107 24 23.565 | 47 54 32.046 |
| 8. | 107 24 23.355 | 47 54 32.116 |
| 9. | 107 24 21.223 | 47 54 33.029 |
| 10. | 107 24 19.708 | 47 54 31.672 |
| 11. | 107 24 15.357 | 47 54 34.079 |
| 12. | 107 24 15.728 | 47 54 34.484 |
| | | 48707 $м^2$ |

***Орон нутгийн санал:*** Горхи-Тэрэлжийн Байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны даргын 2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 22/695 дугаар санал, хүсэлтийн дугаар Е-Монголиа О99-2210-000056-ийг тус тус үндэслэв.

| | Ерөнхий үнэлгээний гол шалгуурууд | Нийцсэн | Нийцээгүй | Нарийвчилсан үнэлгээ хийх шаардлагатай | Үндэслэл, тайлбар |
|---|---|---|---|---|---|
| Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийн нийцэл | Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа байгаль орчныг хамгаалах болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль тогтоомжийн холбогдох заалт | Тийм | | | |
| Төрийн бодлого, шийдвэрийн нийцэл | Төрөөс баримтлах бодлогын баримт бичиг, Стратегийн үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийн холбогдох заалт | Тийм | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Төслийн байршил, түүнтэй холбогдох шалгуурууд | Хуулиар хамгаалагдсан газар нутаг байгаа эсэх (урсац бүрэлдэх эх, ойн болон усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, хилийн хамгаалалтын бүс, орон нутгийн тусгай хамгаалалттай газар г.м) | Тийм | | | |
| | Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь хүний нөлөө, байгаль цаг уурын өөрчлөлтөд эмзэг, мэдрэмтгий эсэх | | | Тийм | |
| | Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, түүний ойр орчимд улс, орон нутгийн хэтийн хөгжилд ашиглахаар төлөвлөсөн, сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй газар байгаа эсэх | | | Тийм | |
| | Болзошгүй хуримтлагдах нөлөөлөл үүсгэх эсэх | | | Тийм | |
| Төслийн байгаль орчны нөлөөллийн урьдчилсан үнэлгээ | **Агаарын чанар** | | | | |
| | Бохирдуулагч болон аюултай, хортой бодис агаар мандалд ялгаруулах, эсэх | | | Тийм | |
| | Дуу чимээ, доргио чичиргээ, гэрлийн болон дулааны нөлөөлөл, цахилгаан соронзон цацраг үүсэх, эсэх | | | Тийм | |
| | 1. Төслийн явцад орчны бохирдлыг тооцож, үйл ажиллагаанаас агаарт үзүүлж болзошгүй нөлөөллийг тодорхойлох,<br>2. Төслийн үйл ажиллагаанаас гарах хатуу, шингэн хог хаягдлын байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тогтоож, арилгах, бууруулах, байгаль орчинд халгүй аргаар зайлуулах арга хэмжээг төлөвлөх, | | | | |
| | **Усан орчин** | | | | |
| | Гадаргын болон газрын доорх усны нөөцийн хомсдол үүсэх, эсэх | | | Тийм | |
| | Цэнгэг усны нөөцийг ашиглах, эсэх | | | Тийм | |
| | Гадаргын болон газрын доорх усанд бохирдол үүсэх, эсэх | | | Тийм | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 1. Газрын доорхи болон гадаргын усны нөхцөл байдлыг тодорхойлж, төслийн үйл ажиллагааны явцад ашиглах усны эх үүсвэр, хэмжээг тодорхойлж, түүнтэй уялдуулан нарийвчилан тооцох;<br>2. Төслийн үйл ажиллагаанаас усны нөөц, горим чанарт үзүүлэх нөлөөллийг тогтоож, түүнд тавих хяналт, хугацаа, хөрөнгө зардлыг нарийвчилан тооцох;<br>3. Усны алдагдлыг багасгах, усыг хэмнэлттэй ашиглах технологийн хувилбарыг судалж, тайланд тусгах;<br>4. Ахуйн бохир усны хэмжээ, найрлагыг нарийвчилан тогтоож, түүнийг байгаль орчинд халгүйгээр зайлуулах арга хэмжээ, түүнд шаардагдах зардлыг тооцох;<br>5. Усны тухай хууль, тогтоомж болон бусад хууль тогтоомжоор хориглосон хязгаарласан бүсийн дэглэмийг зөрчихгүй байх талаар зөвлөмж боловсруулж тайланд хавсаргах, | | | | |
| | **Хөрсөн бүрхэвч** | | | | |
| | Хөрсөн бүрхэвч эвдрэх, эсэх | | | **Тийм** | |
| | Хөрс бохирдуулах эсэх | | | **Тийм** | |
| | Хөрс доройтох, цөлжих эсэх | | | **Тийм** | |
| | 1. Төслийн үйл ажиллагааны явцад хөрс, газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөлөл, түүнийг багасгах, арилгах, цөлжилт, хөрсний эвдрэлээс урьдчилан сэргийлэх арга зам, түүнд шаардагдах хөрөнгө зардлыг төлөвлөх;<br>2. Хатуу, шингэн хог хаягдал, техник технологийн ашиглалтын явцад хөрс бохирдуулахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөх;<br>3. Олон салаа зам гаргах, хөрс бохирдох, эвдрэхээс сэргийлэх, тогтсон нэг орц, гарцыг тогтоох;<br>4. Эвдэрсэн газрыг нөхөн сэргээх төлөвлөгөөг холбогдох зураг төслийн хамт боловсруулж, тайланд хавсаргах; | | | | |
| | **Ургамлан нөмрөг** | | | | |
| | Ургамлан нөмрөг, ой мод өртөх эсэх | | | **Тийм** | **Ургамлан нөмрөг өртөнө.** |
| | Ховор, нэн ховор ургамлын төрөл зүйлс өртөх, эсэх | | | **Тийм** | **Нарийвчилсан үнэлгээгээр тодорхойлох** |
| | 1. Төслийн үйл ажиллагаа явуулахад өртөх талбайн ургамлын нэр төрөл, тархалтыг тогтоох, ховор болон нэн ховор ургамал байгаа эсэх талаар дүгнэлт гаргаж, хэрэв тэдгээр нь төслийн үйл ажиллагааны явцад өртөхөөр байвал түүнийг хамгаалах, болон шилжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгө зардлыг төлөвлөх;<br>2. Эдэлбэр газар, орчныг тохижуулах, ногоон байгууламж байгуулах талаар мэргэжлийн түвшний зөвлөмжийг шаардагдах зардлын хамт боловсруулж, тайланд тусгах;<br>3. Төслийн үйл ажиллагааны улмаас сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй биологийн төрөл зүйлийн бүрэлдэхүүнийг нарийвчилан тогтоож, хамгаалах арга замыг цогц байдлаар шийдэхэд заавар, зөвлөгөө өгөх, тайланд тусгах; | | | | |
| | **Амьтны аймаг** | | | | |
| | Зэрлэг амьтдын амьдрах орчинг доройтуулах, эсэх | | | **Тийм** | |
| | Ховор, нэн ховор амьтан өртөх, эсэх | | | **Тийм** | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 1. Төсөл хэрэгжих нутаг орчмын амьтны аймагт үзүүлэх нөлөөллийг тооцож, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг төлөвлөх; | | | | |
| Нийгмийн нөлөөллийн урьдчилсан үнэлгээ | **Нутгийн оршин суугчид** | | | | |
| | Газар эзэмших, ашиглах эрх зөрчигдөх, эсэх | **Тийм** | | | |
| | Нутгийн оршин суугчдын нийгмийн байдалд сөрөг нөлөөлөлтэй, эсэх | | | **Тийм** | |
| | Нөлөөлөлд өртөж болзошгүй төв, суурин газар байгаа, эсэх | | | **Тийм** | |
| | Нүүлгэн шилжүүлэх асуудал үүсэх, эсэх | | | **Тийм** | |
| | **Түүх, соёлын биет өв** | | | | |
| | Сөрөг нөлөөлөлд өртөх түүх, соёлын үнэт зүйлс бий эсэх | | | **Тийм** | |
| | 1. Төсөл хэрэгжих бүс нутгийн түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээг холбогдох зардлын хамт тайланд тусгах; | | | | |
| | **Хүний эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөлөл** | | | | |
| | Нутгийн иргэд, оршин суугчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх эсэх | | | **Тийм** | |
| | Төслийн бүх үе шатанд хүний эрүүл мэнд, амь насанд эрсдэл үүсэх эсэх | | | **Тийм** | |
| | 1. Төслийн үйл ажиллагаа болон байгалийн гамшгаас үүдэн гарч болзошгүй ослын үнэлгээ хийж, ослоос сэргийлэх, түүнийг багасгах, арилгах арга хэмжээг тодорхойлж тайланд тусгана. | | | | |

**Нэгдсэн дүгнэлт:**
**Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлээр уг төсөлд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын “Аргачлал батлах тухай” 2014 оны А-117 дугаар тушаалын хавсралтын дагуу хийлгэн, нарийвчилсан үнэлгээний тайланг тус яаманд 2022 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлж, шүүмж хийлгэн, шийдвэр гаргуулах шаардлагатай гэж үзлээ.**

**Онцгойлон анхаарах зүйлс:**
1. Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон Байгаль орчны сайдын 2010 оны 156 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны хохирлын үнэлгээ, нөхөн төлбөр тооцох аргачлал”-ын дагуу төслийн үйл ажиллагаанаас ургамал, хөрс, амьтан, агаар орчинд учруулах хохирлыг байгалийн бүрэлдэл тус бүрээр тогтоож, улмаар тухайн газрыг эвдрэлд оруулснаар учирч болох хохирлыг урьдчилан тооцож нийлбэр үнэлгээ гарган төслийг хэрэгжүүлэх байгаль орчны хариуцлагын болон эдийн засгийн үндэслэлийг тодруулж дүгнэлт гаргах;
2. Байгаль орчны төлөв байдлын үнэлгээгээр тогтоогдсон тухайн орчны байгалийн нөөц, хүний эрүүл мэндэд төслийн үйл ажиллагаанаас шууд болон шууд бусаар нөлөөлөх сөрөг нөлөөллийг нарийвчлан тогтоож, шаардагдах зардлыг боловсруулах;
3. Төслийн үйл ажиллагааны явцад гарах ахуйн хог хаягдал болон ашиглагдаж байгаа тоног төхөөрөмж, тусгай ангиллын хог хаягдлыг хүний эрүүл мэнд, байгаль орчинд халгүй аргаар

цуглуулах, ангилан ялгах, дахин ашиглах, устгах, зайлуулах аргыг нарийвчлан тооцож, төслийн үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг болгон хог хаягдлыг байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүйгээр устгах, зайлуулах талаар зөвлөмж боловсруулах;

4. “Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 10[1] дүгээр зүйлд заасны дагуу байгаль орчны төлөвлөгөөт аудитыг 2 жил тутамд төслийн үйл ажиллагаанд хийх асуудлыг холбогдох зардлын хамт тайланд тусгах;
5. Аяллын хөтөлбөр, маршрут нь байгаль хамгааллын зорилго, байгалийн үнэт зүйлсийг хамгаалах үндсэн чиглэлтэй хэрхэн уялдаж байгаад дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулах;
6. Төслийн үйл ажиллагааны явцад унд ахуйд ашиглах цэвэр усны хэрэглээний хэмжээг эх үүсвэртэй уялдуулан, түүнээс гарах ахуйн бохир усыг тус тус нарийвчилан тооцох;
7. БОННҮ-нд байгаль орчинд ээлтэй, олон улсын стандартад нийцсэн технологийг ашиглах талаар заавар, зөвлөмжийг боловсруулах; (Ариун цэврийн байгууламж, дулааны асуудал...)
8. Гэрээгээр ашиглах газрын орчныг тохижуулж, зүлэгжүүлэх, ногоон байгууламж байгуулах төсөл, боловсруулж хэрэгжүүлэх;
9. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг 5 жилээр боловсруулж, тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг төслийн хүчин чадал, төслийн үйл ажиллагааны өрнөлтийн байдалтай уялдуулан тооцож, төлөвлөх;
10. Төслийг “Тусгай хамгаалалттай газар нутаг дахь, эко аялал жуулчлалын зориулалттай байр, сууц. Үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” MNS 6426:2013 стандартын шаардлага хангаж буй эсэх талаар дүгнэлт, зөвлөмж боловсруулж тайланд хавсаргах;
11. Аялал жуулчлалын байр сууцны төрөл үндсэн шаардлага MNS 5824:2007, Амралтын газар, жуулчны бааз гэр буудалд тавих ерөнхий шаардлага MNS 6043:2009, Жуулчны баазын үйлчилгээ чанарын зэрэглэл үндсэн шаардлага MNS 4934:2002: стандартуудыг мөрдөж ажиллах зөвлөмж боловсруулах;
12. Холбогдох хуулинд нийцүүлэн эрх бүхий байгууллагаар баталгаажсан барилга байгууламжийн зураг төсөл, тухайн газарт хэрэгжих төслийн талаарх мэдээлэл, шинжилгээний дүн мэдээг тус тус тайланд хавсаргах;
13. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны 12 дугаар сарын 01-ний А/331 дугаар тушаалын хэрэгжилтийг хангуулж, тодорхой шийдэл бүхий технологийг зөвлөмжөөр тайланд тусгах;
14. Нарийвчилсан үнэлгээ хийх явцдаа тухайн газрыг хариуцан хамгаалж буй хамгаалалтын захиргаанд төслөө танилцуулж, санал авч тайланд хавсаргах;
15. Ойн сан бүхий хил газрын хил хязгаартай давхцалтай эсэх лавлагааг БОАЖЯ-наас авч тайлан хавсаргах;
16. Төсөл хэрэгжих тухайн бүс нутагт Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулинд зааснаас өөр зориулалтаар газрыг ашиглахгүй байх;
17. Төсөлд өөрчлөлт орох, эсхүл өргөтгөх, шинэ тоног төхөөрөмж, технологи нэвтрүүлэх бүрт Ерөнхий үнэлгээнд хамрагдахаар тайланд тусгах;
18. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 10, 11 дүгээр зүйлд заасан хязгаарлалтын бүсийн дэглэмийн дагуу үйл ажиллагаа явуулах, 12 дугаар зүйлд заасан хориглосон үйл ажиллагаа явуулахгүй байх;

**Заавал хэрэгжүүлэх шаардлагатай дээр дурдсан арга хэмжээг цаг хугацаанд нь хангаж биелүүлээгүй тохиолдолд ерөнхий үнэлгээний дүгнэлтийг хүчингүй болгож, “Зөрчлийн тухай хуулийн 7.1 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасны дагуу хариуцлага тооцдог болохыг анхаарна уу.**

| **Бусад зүйлс:**<br>1. Байгаль орчныг хамгаалах болон байгалийн нөөц баялгийг зохистой ашиглахтай холбогдсон хууль тогтоомжийг биелүүлэх талаар байгаль орчин, мэргэжлийн хяналтын байгууллагуудтай байнга хамтран ажиллах;<br>2. Нарийвчилсан үнэлгээний тайланд шүүмж хийлгэн дүгнэлт, шийдвэр гаргуулах асуудлыг ерөнхий үнэлгээгээр тогтоосон хугацаанд хэрэгжүүлэх;<br>3. Ерөнхий үнэлгээнд заасан чиглэл, нөхцөл, болзлоос өөр үйл ажиллагаа явуулах болон төсөлд өөрчлөлт орох, эсхүл өргөтгөх, шинэ тоног төхөөрөмж, технологи нэвтрүүлэх бүрт Ерөнхий үнэлгээнд хамрагдаж байх; | |
|---|---|
| Ерөнхий үнэлгээ хийсэн<br><br>Албан тушаал: Байгаль орчин, аялал жуулчлалын яамны шинжээч<br><br>Овог, нэр: О.Анударь<br><br>Гарын үсэг:<br><br>Огноо: 2022.10.19 | Ерөнхий үнэлгээний үр дүнг зөвшөөрсөн:<br><br>Албан тушаал: “Дүнхэн уулын буурал улиастай” ХХК-ийн захирал<br><br>Овог, нэр: Д.Хандсүрэн<br><br>Гарын үсэг:<br><br>Огноо: ...................... |

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн А/378 дугаар тушаалын 1 дугаар хавсралт

**БАТЛАВ.**
**ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ БҮС НУТГИЙН УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Г.ЭРДЭМБИЛЭГ**

# ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГТ ГАЗАР АШИГЛАХ ТУХАЙ ГЭРЭЭ

**2022 оны 12 дугаар сарын 15-ны өдөр** **№ 2022/66** **Улаанбаатар хот**

Монгол Улсын "Газрын тухай" хуулийн 34 дугаар зүйл, "Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай" хуулийн 33 дугаар зүйлийн 1.36 дугаар зүйлийн 1.37 дугаар зүйлийн 37.1 дэх заалтуудыг үндэслэн:

Нэг талаас ***Улаанбаатар*** хотын ***Налайх*** дүүргийн Засаг дарга-г төлөөлж ***Чойжинсамбуу*** овогтой ***Раднаабазар***, ***Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын*** хамгаалалтын захиргааны дарга ***Мэндсайхан*** овогтой ***Эрдэнэбулган*** цаашид "газар ашиглуулагч" гэх, Нөгөө талаас **"Дүнхэн уулын буурал улиастай" ХХК** /иргэн, аж ахуйн нэгж ,байгууллага/-ийг төлөөлж захирал төлөөлж ***Дамба*** овогтой ***Хандсүрэн*** цаашид "газар ашиглагч" гэх бид Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших ***Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын*** хилийн зааг дотор ***Буурал улиастай*** хязгаарлалтын бүсэд газар ашиглах (энэхүү) гэрээг байгуулав.

## Нэг. Нийтлэг үндэслэл

Энэхүү гэрээнд салшгүй хэсэг болох дараахь зүйлийг заавал тусгах бөгөөд эдгээрийн бүрдэл дутуу бол гэрээг хүчингүйд тооцох үндэслэл болно.

1. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2014 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн 2014/417 дугаар тушаал, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/414 дугаар тушаал, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн А/333 дугаар тушаалын хуулбар

2. Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газрын даргын 2014 оны 12 дугаар сарын 09-ны өдөр олгосон Улсын тусгай хамгаалалттай нутаг дэвсгэрт газар ашиглах 2014/132 тоот гэрчилгээ, хавсралтын хамт.

3. Газрын байршил, хэмжээ, хил хязгаар, заагийг тодорхой харуулсан кадастрын зураг, эргэлтийн цэгийг

4. Газрын төлөв байдлын тухай мэдээлэл: Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий болон нарийвчилсан үнэлгээний дүгнэлт

5. Хамгаалалтын захиргаанаас газар ашиглагч иргэн, аж ахуйн нэгж байгууллагад тус газрыг хүлээлгэн өгсөн тухай акт

6. Газрын төлөв байдал чанарын улсын хянан баталгааг Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийлгүүлж баталгаажуулсан баримт.

7. Хамгаалалтын захиргааны менежментийн төлөвлөгөөнд нийцсэн төсөл.

8. Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт.

9. Тухайн жилд батлагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө.

### Хоёр.Гэрээний нөхцөл

2.1. Газар ашиглах зориулалт: ***Аялал жуулчлал***

2.2. Газар ашиглагчид олгосон нийт талбайн хэмжээ **: 48707 м2**

2.3. Газрын төлбөрийн хэмжээ: ***1020,000*** (***Нэг сая хорин мянган төгрөг***) төгрөг, (дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019.01.14-ны тогтоолоор тогтоосон).

а/ нэгжийн төлбөр **102**

б/ бүгд төлбөр 1 жилд ***4,968,114 /Дөрвөн сая есөн зуун жаран найман мянга нэг зуун арван дөрөв***/ төгрөг

в/ **Төлбөр хийх хугацаа**: Газрын төлбөрийг тэнцүү хэмжээгээр улирал бүрийн эхний сарын 25-ны дотор (хугацаандаа төлсөн байх) ***Нийслэлийн Газрын Алба Хаан банк 5749063361*** тоот дансанд төлнө.

г/ Эрх бүхий байгууллагын шийдвэрээр газрын төлбөрийн хэмжээ өөрчлөгдөх тохиолдолд гэрээнд өөрчлөлт оруулна. Газрын төлбөрийг шинэчлэн тогтоолгоогүй бол хариуцлагыг газар ашиглагч хүлээнэ.

2.4. Газар ашиглах гэрээний хугацаа:

а/ эхлэх : **2019-11-26**

б/ дуусах : **2024-11-26**

2.5. Газрын төлбөрийг Байгаль орчны асуудал эрхэлсэн сайдын шийдвэр гарсан өдрөөс эхлэн тооцно.

### Гурав. Газар ашиглагчийн эрх, үүрэг

1. ***"Дүнхэн уулын буурал улиастай"*** ХХК нь газрыг зориулалтын дагуу байгаль орчны төлөв байдалд сөрөг нөлөөлөлгүй ашиглан, Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ, тухайн жилийн Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлсэн талаарх тайланг жил бүр хамгаалалтын захиргаанд тайлагнах.

а. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний нийт зардал ***23.220.000*** төгрөг

б. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний нийт зардал ***5.050.000*** төгрөг байна.

Бүгд зардал ***28.270.000*** төгрөг

2. Газар ашигласны төлбөрийн хувь хэмжээг "Газрын төлбөрийн тухай" хуулийн 7 дугаар зүйлийн 7.6 дахь хэсгийг үндэслэн ногдуулж орон нутгийн төсөвт төвлөрүүлнэ.

3. Газрын төлбөрийг газрыг ашигласан эсэхээс үл хамааран хугацаанд нь бүрэн төлөх, хугацаандаа төлөөгүй тохиолдолд төлбөрийн үнийн дүнгийн 0.5 хувиар хоног тутам алданги төлөх.

4. Энэхүү гэрээний 1/нэг/ хувийг Налайх дүүргийн газрын албанд бүртгүүлнэ.

5. Байгаль орчныг хамгаалах тухай, Газрын тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Ойн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдөх, хуулийн дагуу мод тарих ажлыг жил бүр зохион байгуулж, үр дүнг хамгаалалтын захиргаанд хүлээлгэн өгөх.

6. Үйл ажиллагаа эхлэхдээ гэрчилгээний солбицлын цэгийг тусгай зөвшөөрөл бүхий байгууллагаар тогтоолгон, ерөнхий төлөвлөгөө батлуулж, байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ, холбогдох бичиг баримтыг хамгаалалтын захиргаанд хянуулж ажил эхлэх зөвшөөрөл авах.

7. Газар ашиглагч нь төслөө өргөтгөх, шинэчлэх тохиолдолд Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газраас зөвшөөрөл авч, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг дахин хийлгэж, газар ашиглах гэрээг шинэчлэн байгуулна.

8. ТХГН-ийн тухай хуулийн 37-р зүйлийн 37.2.1 заасны дагуу тусгай хамгаалалттай газрын унаган төрхийг хадгалах, хамгаалах, нөхөн сэргээх талаар авах арга хэмжээ, /усны эх булаг шанд хамгаалах, хориглосон, зөвшөөрсөн, анхааруулсан тэмдэг тэмдэглэгээ, хамгаалалтын хашаа, зогон татах, нөхөн сэргээлт, судалгаа шинжилгээ г.м/ түүнд зарцуулах хөрөнгө тэдгээрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардал жил бүр ***1000,000 /Нэг сая төгрөг/*** төгрөгөөс хамгаалалтын захиргаанд 40/Горхи-Тэрэлжийн БЦГ-ын хамгаалалтын захиргаа Төрийн сан 100900013072/ хувь, орон нутагт 60 хувь/Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ /-ийг тус тус төвлөрүүлнэ.

9. Зориулалтын дагуу үйл ажиллагаа явуулж дууссаны дараа төсөл, төлөвлөгөөнд заасны дагуу газрыг стандарт, норм, шаардлагын дагуу нөхөн сэргээж, хамгаалалтын захиргаанд актаар хүлээлгэн өгнө.

10. Гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлж ирсэн бол газар ашиглах гэрчилгээний хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө сунгах хүсэлт гаргах.

11. Газар ашиглах гэрээний дагуу хийж гүйцэтгэсэн ажлын тайланг дараа оны 02 дугаар сарын 25-ны дотор хамгаалалтын захиргаанд хүргүүлэн гэрээг дүгнүүлж, төлбөрийн тооцоо нийлсэн акт үйлдэх.

12. Ашиглахаар авсан газрыг хамгаалалтын захиргаанаас газар хүлээлцэх актаар хүлээн авснаас хойш үүссэн бусдын хууль бус үйлдэл, аливаа зөрчил маргааныг иргэн, аж ахуйн нэгж байгууллага өөрсдөө бүрэн хариуцна.

13. Гэрээгээр ашиглаж байгаа газраа бүхэлд нь буюу зарим хэсгийг бусдад дамжуулан ашиглуулсан нөхцөлд газар ашиглах эрхийг цуцална.

14. Ашиглаж байгаа газар дээр харь зүйлийн мод бут сөөг ургамлыг тарьж урслуулэх, ургаж байгаа мод шилжүүлэхийг хориглоно.

15. Зөвшөөрөлгүй худаг гаргах, стандартын бус ариун цэврийн байгууламж барих, шороон зам гаргахыг хориглоно.

16. Хамгаалалтын захиргааны зөвшөөрөлгүй зэрлэг амьтан тэжээхийг хориглоно.

17. Гэрээнд заасан албан ёсны хаяг, утас, цахим хаяг өөрчлөгдсөн тохиолдолд 14 хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ.

18. Хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх, үүрэг, хариуцлага хүлээх

19. Хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.3 аж ахуйн нэгж, байгууллага нь хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай хог тээврийн үйлчилгээний гэрээ байгуулах

20. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь ойр орчны 50 м газарт тохижилтийн ажил хийх, төв замаас өөрийн ашиглалтын талбай хүртэлх авто замыг засан сайжруулах

**Дөрөв. Хамгаалалтын захиргааны эрх, үүрэг**

1. Байгаль орчны асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүний газар ашиглах эрх олгосон тушаал, Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг үндэслэн газар ашиглуулах тухай гэрээг газар ашиглагчтай байгуулна.

2. Аж ахуйн нэгжийн ашиглах газрын хэмжээ, байршил, хилийн заагийг тогтоох

3. Ашиглах газрын хилийн заагийг гэрчилгээний солбицлын дагуу тогтоосон эсэхэд хяналт тавих

4. Газар ашиглалт, хамгаалалтын байдалд хяналт тавьж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад чиглэл, даалгавар өгч биелэлтийг хангуулах

5. Газар ашиглагчаас ашиглалттай холбоотой шаардлагатай бичиг баримтыг гаргуулан авах

6. Барилга байгууламж барих ажлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж байгаад хяналт тавих;

7. Ойг нөхөн сэргээх талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад чиглэл, даалгавар өгч биелэлтийг хангуулах

8. Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал болон газар ашигласан төлбөрийн зохих хэсгийг байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах.

9. Гэрээний хэрэгжилтэнд хяналт тавьж, газар ашиглах гэрээг сунгах эсэх саналыг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх.

10. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон холбогдох баримт бичгийн хэрэгжилтийг *"Тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлалын үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх байдлыг шалгах хяналтын хуудас"*-аар хэрэгжилтийг шалгаж, зөрчлийг арилгуулах.

11. Газар ашиглагчийн гэрчилгээ, гэрээ сунгах талаар ирүүлсэн хүсэлтийг судалж, дүгнэлт гарган Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад санал хүргүүлэх

### Тав. Сум, дүүргийн Засаг даргын эрх, үүрэг

1. Байгаль орчны төрийн захиргааны төв байгууллагын шийдвэр, гэрчилгээг үндэслэн газар ашиглуулах тухай гурвалсан гэрээг байгуулна.

2. Газар ашигласны төлбөрийн хувь хэмжээг "Газрын төлбөрийн тухай" хуулийн 7 дугаар зүйлийн 7.6 дахь хэсгийг үндэслэн хоогдуулж орон нутгийн төсөвт төвлөрүүлнэ.

3. Газар ашиглагчдын газрын төлбөрийн мэдээллийг жил бүрийн 01 дүгээр сарын 25-ны өдрийн дотор хамгаалалтын захиргаа, Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

4. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн дагуу газар нөөц ашигласны төлбөрийн 30 хувийг /орон нутагт 20 хувь, хамгаалалтын захиргаанд 10 хувь/-ийг хамгаалалтын захиргаатай хамтран байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах

5. Гэрээний хэрэгжилтэнд хяналт тавьж, гэрээг жил бүр дүгнэж, гэрчилгээний хугацаа дуусахад сунгуулах хүсэлтэнд санал өгнө.

6. Газар ашиглах гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдолд гэрээ цуцлах саналыг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

### Зургаа. Гэрээг дуусгавар болох тохиолдол

1. Газрыг гэрээний нөхцөлийн дагуу ашиглаагүй зориулалтыг өөрчилсөн, газрын хэмжээг хэтрүүлсэн, Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.1-40.1.6 дугаар зүйлд заасан нөхцөл бий болсон, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, тусгай хамгаалалттай газрын нийтлэг горимыг 2 удаа зөрчсөн, байгаль орчны нөлөөллийн



1118262683 5690897
AMT02242

үнэлгээгээр тавигдсан шаардлагыг биелүүлээгүй гэрээг дүгнүүлээгүй бол газар ашиглах эрхийг хуульд заасан үндэслэлээр дуусгавар болгож эрхийн гэрчилгээг хүчингүй болгоно.

## Долоо. Бусад зүйл

1. Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж баталсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

2. Гэрээний биелэлтийг талууд дараа оны 02 дугаар сарын 25-ны дотор дүгнэж, шаардлагатай бол гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулна.

3. Энэхүү гэрээг **2022 оны 11 дүгээр сарын 01**-ний өдөр байгуулж, 4 хувь үйлдэн Байгаль орчны асуудал эрхэлсэн тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газар, хамгаалалтын захиргаа, сум, дүүргийн Засаг дарга, **"Дүнхэн уулын буурал улиастай"** ХХК / иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тус бүр нэг хувийг хадгална.

4. Газар ашиглах эрх хүчингүй болсон, гэрээний хугацаа дуусгавар болоход газар дээрх эд хөрөнгийн эрхийн асуудлыг Газрын тухай хуулийн 47 болон 49 дүгээр зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.

Гэрээ байгуулсан:

***ГОРХИ-ТЭРЭЛЖИЙН БЦГ-ЫН***
ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНЫ ДАРГА

***/М.ЭРДЭНЭБУЛГАН/***

Хаяг: ***Налайх дүүрэг 1 хороо Туулын гүүр***
Утас, факс: **70232277, 70232288**

***НАЛАЙХ ДҮҮРГИЙН***
ЗАСАГ ДАРГА

***/Ч.РАДНААБАЗАР/***

Хаяг: ***Налайх дүүрэг 2 хороо***
Утас, факс: **70233348**

***"ДҮНХЭН УУЛЫН БУУРАЛ УЛИАСТАЙ"*** ХХК ( иргэн, аж ахуйн нэгж, байгууллага )-ыг төлөөлж захирал

***/...ХАНДСҮРЭН/***

Хаяг: ***УБ хот БЗД 14 хороо, 14 хороолол, Намъянжүгийн гудамж***
***Дугуй булант Баянхайрхан трейд өөрийн байр 31В-402 тоот***
Утас: факс: **88103126, 70150044**

***Горхи-Тэрэлжийн БЦГ-т үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авсан "Дүнхэн уулын буурал улиастай" ХХК-ний байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ, газар ашиглах гурвалсан гэрээний хэрэгжилт***

2018.08.27

| ААН-н УБ дугаар, РД | УБД: 9011508018 | РД: 5884276 |
|---|---|---|
| Тайлбар: | | |
| ААНБ-ын хаяг, шуудангийн хаяг, вэб болон Е-мэйл хаяг | БЗД 14 хороо, 14 хороолол, Намъянжүгийн гудамж Дугуй булант Баянхайрхан трейд өөрийн байр 31В-402 тоот | Захирал Д.Хандсүрэн Утас: 88103126, 89114555 |
| Ашиглах газрын байршил | Горхи-Тэрэлжийн БЦГ | Горхийн баруун салаа |
| Газрын хэмжээ | 1.9 | |
| Гэрчилгээний дугаар | 2014.12.09 | 2014/132 |
| Гэрчилгээний сунгалт | | |
| Гэрээ байгуулсан он, хугацаа | 2015.05.07 | 2014.12.09<br>2019.12.09 |
| БОНБЕ болон нарийвчилсан үнэлгээний мэдээлэл | Ерөнхий үнэлгээ | |
| Төслийн нэр | Аялал жуулчлал | |

**Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ**

| | Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд тусгасан заалт | Хэрэгжилт |
|---|---|---|
| 1 | Аялал жуулчлалын зориулалтаар | 3 давхар бүхий зочид буудал, 19 гэр, 19 байшин, ажилчдын байр |
| 2 | Цахилгаан төвлөрсөн төвийн, дулаан цахилгаанаар , цэвэр усны хангамж гүний худаг. | 380 бүхий цахилгаанд холбогдсон. Гүний худагтай. Цэвэрлэх байгууламжтай. |

**Гурвалсан гэрээ дүгнэсэн акт**

| № | Гурвалсан гэрээнд тусгагдсан хүлээх үүрэг | Хэрэгжилт |
|---|---|---|
| 1 | Тусгай хамгаалалттай газар нутгийн горимыг мөрдөх, зөвхөн тогтоосон газарт гэрээнд заасан зориулалтын дагуу үйл ажиллагаа явуулна | Тогтоосон газартаа аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг. |
| 2 | Газар ашиглалтын гэрээг холбогдох байгууллагатай хийж албажуулан хэрэгжүүлэх | Гурвалсан гэрээг батлуулж мөрдөж ажиллаж байна. |
| 3 | Газар ашиглалтын төлбөрийг Налайх дүүргийн төсвийн дансанд оруулах | 2018 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар төлбөрийн тооцоогүй. |
| 4 | Байгалийн унаган төрхийг хадгалан хамгаалах, нөхөн сэргээх талаар Хамгаалалтын захиргаанаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх | Байгалийн унаган төрхийг хадгалах, Горхи-Тэрэлжийн БЦГ-ын хамгаалалтыг сайжруулах, нөхөн сэргээх ажилд тогтмол идэвхитэй оролцсон. |

Дүгнэлт гаргасан:

Хамгаалалтын захиргааны мэргэжилтэн: С.Бэлэгсайхан

ҮЛДЭЛТ ... БАЙЦААГЧ 39-04-177

## ГАЗРЫН ТӨЛБӨРИЙН ТООЦОО НИЙЛСЭН АКТ
## №01113-2021/01352

Огноо: 2022-04-18

| Эрх зүйн харилцааны мэдээлэл | |
|---|---|
| **Засаг даргын шийдвэрийн огноо:** | 2014-11-26,01113-А-417/2021 |
| **Газар эзэмшүүлэх, ашиглуулах гэрээний дугаар:** | 01113-2021/01352 |
| **Газар эзэмшигч иргэн, хуулийн этгээдийн нэр:** | "Дүнхэн уулын буурал улиастай" ХХК |
| **Регистрийн дугаар:** | 5884276 |
| **Нэгж талбарын дугаар, гэрчилгээний дугаар:** | 1260711469,0 |
| **Газрын улсын бүртгэлийн дугаар:** | А-2207000018 |
| **Газрын байршил, зориулалт:** | 6-р хороо Антын ам /12739/ 173, Аялал, жуулчлалын бааз |
| **Утасны дугаар:** | 880815 88081562 |
| **Талбайн хэмжээ:** | 18123 |
| **Газрын жилийн төлбөр:** | 1848546 |
| **Газар эзэмших хугацаа:** | 5 |

Газрын төлбөр төлсөн байдлыг хүснэгтээр үзүүлэв:

| № | Төлбөр тооцсон хугацаа /он/ | Нөхөн төлбөр, алданги, торгууль /төг/ | Тухайн онд төлөх төлбөр /төг/ | Нийт төлөх төлбөр /төг/ | Төлсөн төлбөр /төг/ | Төлбөрийн үлдэгдэл /төг/ |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2021 | 1938000 | 1848548 | 3786548 | 3786548 | 0 |
| 2 | 2022 | | 1848546 | 1937998 | 1937998 | 0 |
| | **Дүн** | **1938000** | | **5635094** | **5724546** | **0** |

**2022-12-31-ний өдрийг хүртэл газрын төлбөрийн үлдэгдэл 0 төгрөг байна.**

**Газрын төлбөрөө нэхэмжлэхийн дагуу хугацаанд нь төлнө үү.**

Тооцоо нийлсэн: Нийслэлийн Налайх дүүргийн газар зохион байгуулалтын алба-ны төлбөрийн мэргэжилтэн /Э.Ууганбаяр/

Зөвшөөрсөн: "Дүнхэн уулын буурал улиастай" ХХК/

Хянасан: Дүүргийн Газар зохион байгуулалтын албаны дарга /Ж.Тамир/

**Горхи-Тэрэлжийн БЦГ-т үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авсан "Дүнхэн уулын буурал улиастай" ХХК-ний байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ, газар ашиглах гурвалсан гэрээний хэрэгжилт**

2022.04.18

| ААН-н УБ дугаар, РД | УБД: 9011508018 | РД: 5884276 |
|---|---|---|
| Тайлбар: | | |
| ААНБ-ын хаяг, шуудангийн хаяг, вэб болон Е-мэйл хаяг | БЗД 14 хороо, 14 хороолол, Намъянжугийн гудамж Дугуй булант Баянхайрхан трейд өөрийн байр 31В-402 тоот | Захирал Д.Хандсүрэн Утас: 88103126, 99089994 99113126 |
| Ашиглах газрын байршил | Горхи-Тэрэлжийн БЦГ | Буурал улиастай |
| Газрын хэмжээ | 1.9 | |
| Гэрчилгээний дугаар | 2014.12.09 | 2014/132 |
| Гэрчилгээний сунгалт | 2022.01.11 | 2019.11.26 2024.11.26 |
| Гэрээ байгуулсан он, хугацаа | 2022.04.01 | 2019.11.26 2024.11.26 |
| БОНБЕ болон нарийвчилсан үнэлгээний мэдээлэл | Ерөнхий үнэлгээ 2018/Е125 | Нарийвчилсан үнэлгээ 2018 |
| Төслийн нэр | Аялал жуулчлал | |

**Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ**

| | Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд тусгасан заалт | Хэрэгжилт |
|---|---|---|
| 1 | Аялал жуулчлалын зориулалтаар | Газар дээр 25 байшин, 5 гэр, ажилчдын байр зэрэг хашаатай. |
| 2 | Цахилгаан төвлөрсөн төвийн, дулаан цахилгаанаар , цэвэр усны хангамж гүний худаг. | Цахилгаан, холбоо сүлжээ, техникийн нөхцөл бүрэн хийгдсэн. |

**Гурвалсан гэрээ дүгнэсэн акт**

| № | Гурвалсан гэрээнд тусгагдсан хүлээх үүрэг | Хэрэгжилт |
|---|---|---|
